

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2023/95/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Өлгий хот  
2023 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: М.Хуанган  
Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn  
Аудитын менежер: Х.Женисбек  
Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn  
Ахлах аудитор: С.Нурлан  
Утас: 88403281 Цахим хаяг: nurlans@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

## **АГУУЛГА**

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
Асуудлыг онцолсон хэсэг .....	<b>Error! Bookmark not defined.</b>
Аудитын гол асуудал.....	<b>Error! Bookmark not defined.</b>
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	<b>Error! Bookmark not defined.</b>
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал.....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
4.5.1 Завсрын аудитын талаар.....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	16
5.1 Төлбөрийн акт .....	16
5.2 Албан шаардлага .....	16
5.3 Зөвлөмж.....	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	17

### **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын стандарт

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgii@audit.gov.mn

УЛААНХУС СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН 1 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Х.БЕРДЕНБЕК ТАНАА

2023.08.24 № 123  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанхус сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Сургуулийн 2022 оны санхүүгийн тайлантай холбоотой онцлог асуудал байхгүй байна.

### Аудитын гол асуудал

Хүнсний материал 92.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь материаллаг эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татах асуудал байна.

### Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>124654047.79</u></b>	<b><u>228532856.16</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	0.00	67144199.61
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	0.00	67144199.61
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	0.00	67144199.61
31211	Төрийн сангийн харилцах	0.00	67144199.61
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	124654047.79	161388656.55
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	124654047.79	161388656.55
35420	Аж ахуйн материал	50705107.29	48582077.29
35440	Түлш, шатах тослох материал	143000.00	0.00
35460	Хүнсний материал	53971917.50	92972556.26
35470	Бусад хангамжийн материал	19834023.00	19834023.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>3708844082.91</u></b>	<b><u>3670741483.80</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	3708844082.91	3670741483.80
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	3675834082.91	3637791483.80
39201	Барилга, байгууламж, орон сууц	4089707009.00	4101381279.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-546579779.08	-631182432.76
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	204945417.56	178164638.41
39206	Хуримтлагдсан элэгдэл	-146032561.84	-86788773.19
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	114218733.73	130497063.73
39208	Хуримтлагдсан элэгдэл	-67978653.18	-77685404.59
39217	Ном	27553916.72	23405113.20
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	33010000.00	32950000.00
39301	Програм хангамж	850000.00	850000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-670000.00	-730000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	32830000.00	32830000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>3833498130.70</u></b>	<b><u>3899274339.96</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>70373481.00</u></b>	<b><u>87005590.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	70373481.00	87005590.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	70373481.00	87005590.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	70373481.00	87005590.00
41361	Байгууллагад төлөх өглөг	70373481.00	87005590.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>3763124649.70</u></b>	<b><u>3812268749.96</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	3763124649.70	3812268749.96
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1471608356.00	1471608356.00
51101	Өмч: - төрийн	1471608356.00	1471608356.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-595119275.24	-539427321.98

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

51210	Өмнөх үеийн үр дүн	-373191661.66	-588571422.24
51220	Тайлант үеийн үр дүн	-221927613.58	49144100.26
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2886635568.94	2880087715.94
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>3833498130.70</b>	<b>3899274339.96</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

				Төгрөгөөр
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,900,914,723.72</b>	<b>2,327,924,689.00</b>	
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>5,059,392.00</b>	-	
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	5,059,392.00	-	
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	5,059,392.00	-	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	5,059,392.00	-	
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,895,855,331.72</b>	<b>2,327,924,689.00</b>	
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,736,979,775.72	2,066,387,189.00	
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	2,023,753,600.00	
131005	Хөрөнгийн санхүүжилт	120,285,375.72	42,633,589.00	
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,616,694,400.00	-	
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	9,078,556.00	-	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,078,556.00	-	
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	149,797,000.00	261,537,500.00	
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	149,797,000.00	261,537,500.00	
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,122,842,337.30</b>	<b>2,271,698,176.22</b>	
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,122,842,337.30</b>	<b>2,271,698,176.22</b>	
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,084,926,799.69	2,193,734,968.59	
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,313,710,291.39	1,534,253,301.36	
210101	Үндсэн цалин	1,222,330,591.39	1,195,639,485.24	
210102	Нэмэгдэл	-	300,803,493.41	
210104	Урамшуулал	77,766,300.00	37,810,322.71	
210105	Гэрээт ажлын хөлс	13,613,400.00	-	
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	177,190,300.00	192,235,300.00	
210201	Тэтгэврийн даатгал	124,689,500.00	130,720,100.00	
210202	Тэтгэмжийн даатгал	13,125,200.00	15,378,900.00	
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,500,100.00	12,303,000.00	
210204	Ажилгүйдлийн даатгал	2,625,100.00	3,075,700.00	
210205	Эрүүл мэндийн даатгал	26,250,400.00	30,757,600.00	
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	148,535,730.00	174,856,359.00	
210301	Гэрэл, цахилгаан	4,453,480.00	12,626,250.00	
210302	Түлш, халаалт	144,082,250.00	162,230,109.00	

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	27,444,928.00	28,235,948.00
210401	Бичиг хэрэг	3,225,106.00	7,927,130.00
210402	Тээвэр, шатахуун	2,116,055.00	3,642,850.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,444,800.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,406,227.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,694,475.00	13,178,668.00
210408	Бараа материал акталсны зардал	9,558,265.00	3,487,300.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	67,918,678.50	104,084,502.64
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	143,300.00	306,000.00
210502	Хоол, хүнс	66,882,578.50	101,684,452.64
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	892,800.00	2,094,050.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,543,650.00	11,546,800.00
210604	Урсгал засвар	2,543,650.00	11,546,800.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	519,000.00	-
210702	Дотоод албан томилолт	519,000.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	600,000.00	10,922,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	10,922,800.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	346,464,221.80	137,599,957.59
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	16,923,282.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,053,800.00	923,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	343,410,421.80	119,752,775.59
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	37,915,537.61	77,963,207.63
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	32,407,500.00	77,963,154.63
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	32,407,500.00	77,963,154.63
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	5,508,037.61	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,508,037.61	-
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	53.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	53.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(221,927,613.58)</b>	<b>56,226,512.78</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	7,082,412.52
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	7,082,412.52
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	(7,082,412.52)
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(221,927,613.58)</b>	<b>49,144,100.26</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

**Төгрөгөөр**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1775569956.00</b>	<b>2285291100.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1775569956.00</b>	<b>2285291100.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1616694400.00	2023753600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		2023753600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1616694400.00	
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	9078556.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9078556.00	
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	149797000.00	261537500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	149797000.00	261537500.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1765702956.00</b>	<b>2172047900.39</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1765702956.00</b>	<b>2172047900.39</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1725987418.39</b>	<b>2081461547.39</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1311834212.39	1534253301.36
210101	Үндсэн цалин	1220454512.39	1195639485.24
210102	Нэмэгдэл		300803493.41
210104	Урамшуулал	77766300.00	37810322.71
210105	Гэрээт ажлын хөлс	13613400.00	
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	177190200.00	192235300.00
210201	Тэтгэврийн даатгал	124689500.00	130720100.00
210202	Тэтгэмжийн даатгал	13125200.00	15378900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	10500100.00	12303000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2625100.00	3075700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	26250300.00	30757600.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	148797000.00	162003500.00
210301	Гэрэл, цахилгаан	5453000.00	11146500.00
210302	Түлш, халаалт	143344000.00	150857000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	11613156.00	0.00
210401	Бичиг хэрэг	962656.00	
210402	Тээвэр, шатахуун	865000.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1571900.00	
210404	Ном, хэвлэл	448700.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1800000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5964900.00	
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	63531850.00	128060446.03
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1086500.00	
210502	Хоол, хүнс	59140550.00	128060446.03
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3304800.00	
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1000000.00	1100000.00
210604	Урсгал засвар	1000000.00	1100000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	519000.00	0.00

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210702	Дотоод албан томилолт	519000.00	
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2142100.00	10922800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1542100.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		10922800.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	9359900.00	52886200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		36053700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9359900.00	16832500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>39715537.61</b>	<b>90586353.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	34207500.00	90586300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	34207500.00	90586300.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	5508037.61	0.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5508037.61	
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	0.00	53.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		53.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>9867000.00</u></b>	<b><u>113243199.61</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>9867000.00</b>	<b>46099000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>9867000.00</b>	<b>46099000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	9867000.00	46099000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	9867000.00	46099000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-9867000.00</u></b>	<b><u>-46099000.00</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	0.00	67144199.61
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		67144199.61

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,471,608,356.00	2,886,635,568.94		4,358,243,924.94
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,471,608,356.00	2,886,635,568.94	0.00	4,358,243,924.94

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

C08	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,471,608,356.00</b>	<b>2,886,635,568.94</b>	<b>-595,119,275.24</b>	3,763,124,649.70
D01	<b>2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>1,471,608,356.00</b>	<b>2,886,635,568.94</b>	<b>-595,119,275.24</b>	3,763,124,649.70
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			6,547,853.00	6,547,853.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,471,608,356.00</b>	<b>2,886,635,568.94</b>	<b>-588,571,422.24</b>	3,769,672,502.70
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		-6,547,853.00		-6,547,853.00
D08	Тайлант үеийн үр дүн			49,144,100.26	49,144,100.26
D09	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,471,608,356.00</b>	<b>2,880,087,715.94</b>	<b>-539,427,321.98</b>	3,812,268,749.96

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

### Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	2285291100.00	2218146847.39
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	2285291100.00	2218146847.39
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2194704800.00	2127560547.39
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1548166800.00	1534253301.36
210101	Үндсэн цалин	1250907500.00	1195639485.24
210102	Нэмэгдэл	259751400.00	300803493.41
210104	Урамшуулал	37507900.00	37810322.71
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	192235300.00	192235300.00
210201	Тэтгэврийн даатгал	130720100.00	130720100.00
210202	Тэтгэмжийн даатгал	15378900.00	15378900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	12303000.00	12303000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3075700.00	3075700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	30757600.00	30757600.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	162003500.00	162003500.00
210301	Гэрэл, цахилгаан	11146500.00	11146500.00
210302	Түлш, халаалт	150857000.00	150857000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	154453100.00	128060446.03
210502	Хоол, хүнс	154453100.00	128060446.03
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1100000.00	1100000.00
210604	Урсгал засвар	1100000.00	1100000.00

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	11388300.00	10922800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11388300.00	10922800.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	125357800.00	98985200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	108275300.00	81902700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17082500.00	17082500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	90586300.00	90586300.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	90586300.00	90586300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	90586300.00	90586300.00
<b>13</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	2285291100.00	2285291047.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	2023753600.00	2023753600.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	2023753600.00	2023753600.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	261537500.00	261537447.00
132001	Орон нутгийн төсвөөс	261537500.00	261537447.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		67144199.61
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	117.00	117.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	76.00	76.00
620003	Үйлчлэх ажилтан	40.00	40.00

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

##### **Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар**

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь сурагчдад анхан болон суурь мэдлэг олгох, сурлагын чанарыг дээшлүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэхээр зорилгыг дэвшүүлэн ажилласан байна.

Дээрх зорилгыг биелүүлэхээр сургууль нь 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан 1 зорилгын хүрээнд 36 арга хэмжээг дэвшүүлж ажилласан байна. Сургуулийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1 зорилгын 36 арга хэмжээг аймгийн Боловсрол шинжлэх ухааны газраас “Хангалттай” гэж үнэлсэн байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

##### **Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар**

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь Боловсролын тухай хууль, Бага дунд боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Улсын Их Хурлаас Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар оруулсан өөрчлөлтөөр боловсролын салбарын байгууллагууд улсын төсвөөс санхүүжиж, БСШУС-ын харьяа Боловсролын ерөнхий газарт санхүүгийн тайлангаа нэгтгэлд тушаадаг болсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Байгууллагын хөтөлбөл зохих нягтлан бодох бүртгэлийг холбогдох заавар журмын дагуу хөтөлж, бараа материалын тайланг гаргаж, цалингийн цэсэд хавсаргах холбогдох тушаал, шийдвэр болон санхүүгийн анхан шатны баримтуудыг зохих журмаар бүрдүүлсэн байна.

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 2022 онд шалгалтад хамрагдаагүй тул дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн захирлын 2020 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн А/211 тоот тушаалаар баталсан НББ-ийн бүртгэлийн бодлогын баримт бичгийг ажилдаа мөрдлөг болгосон байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн ба тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 65.8 сая төгрөгөөр буюу 1.6 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	67,144.2	67,144.2

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Авлага			
Бараа материал	124,654.0	161,388.6	36,734.6
Үндсэн хөрөнгө	3,708,844.1	3,670,741.5	-38,102.6
<b>Нийт хөрөнгө</b>	<b>3,833,498.1</b>	<b>3,899,274.3</b>	<b>65,776.2</b>
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,833,498.1	3,899,274.3	65,776.2
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>3,833,498.1</b>	<b>3,899,274.3</b>	<b>65,776.2</b>

Дээрх хүснэгтээс харахад мөнгө, бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Бараа материалын данс 36.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 262.9 сая төгрөгийн материал худалдан авч, 3.5 сая төгрөгийн материалыг акталж, үйл ажиллагаанд 222.7 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө 38.1 сая төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 46.1 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авч, үнэгүй 42.6 сая төгрөгийн хөрөнгийг хандиваар авч, 91.7 сая төгрөгийн хөрөнгийг акталж, үндсэн хөрөнгөд 119.7 сая төгрөгийн элэгдэл байгуулж байгуулсан элэгдлээс 84.6 сая төгрөгийн элэгдлийн хасалт хийсэнтэй холбоотой байна.

Тайлант оны үр дүнгээр Засгийн газрын хувь оролцоо данс 65.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,563.5 сая, нийт зарлагыг 2,563.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснээс 2,285,3 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн төслийн саналаас цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 74.9 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 26.9 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 34.2 сая төгрөгөөр, Хангамж, бараа материалын зардлын 18.9 сая төгрөгөөр, нормативт зардлыг 74.0 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 1.9 сая төгрөгөөр, томилолт, зочны зардлыг 4.1 сая төгрөгөөр, бусад урсгал шилжүүлгийн зардлыг 165.2 сая төгрөгөөр бууруулж, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрийн зардлыг 6.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж нийт зардлыг 278.2 сая төгрөгөөр бууруулж баталсан байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 10 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,023.7 сая төгрөгийг улсын төсвөөс, 261.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс нийтдээ 2,285.3 сая төгрөгийг бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр улсын болон орон нутгийн төсвөөс 2,285.3 сая төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагаанд 2,218.1 сая төгрөг зарцуулж, 67.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,218.1 сая төгрөг буюу 97.1 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 67.1 сая төгрөгөөр дутуу зарцуулсан байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71802-Ерөнхий боловсрол хөтөлбөрийн				
1.1	80226-Байр ашиглалтын үйлчилгээ арга хэмжээний	4,555.3	4,555.3	0	100%
1.2	80312-Сургалт семинар арга хэмжээ	2,277.7	2,277.7	0	100%
1.3	81605-Эрүүл мэндийг дэмжих арга хэмжээ	5,238.6	4,947.0	291.6	94.4%
1.4	81801-Үдийн цай хөтөлбөр арга хэмжээ	90,586.3	90,586.3	0	100%
1.5	81806-Дотуур байрны үйлчилгээ арга хэмжээ	271,026.7	241,234.2	29,792.5	89%
1.6	81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин арга хэмжээ	71,930.0	45,849.0	26,081.0	63.7%
1.7	81832-Боловсролын байгууллагын багш арга хэмжээ	10,249.5	10,249.5	0	100%
1.8	81834-Боловсролын стандарт, сургалтын арга хэмжээ	1,324,890.3	1,324,424.8	465.5	100%
1.9	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагаа арга хэмжээ	242,999.2	232,485.6	10,513.6	95.6%
1.10	80112-Нийтлэг үйлчилгээ	261,537.5	261,537.5	0	100%
	<b>Дүн</b>	<b>2,285,291.1</b>	<b>2,218,146.8</b>	<b>67,144.3</b>	<b>97.1%</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 2022 онд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Улаанхус сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Нурлан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 04 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Улаанхус сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 1,895.8 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 28.4 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор цалин хөлс болон нэмэгдэл урамшил 13.9 сая төгрөгөөр, нормативт зардлыг 26.4 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 0.5 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 26.3 сая төгрөгөөр нийтдээ 67.1 сая төгрөгөөр хэмнэлттэй зарцуулсан.

Хүнсний материалын үлдэгдэл 92.0 сая төгрөгт хүрч үлдэгдлийг нэмэгдүүлсэн зөрчилд албан шаардлага өгөгдлөө.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс шалгах программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгав.

Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 66.8 сая төгрөгийн 7 шийдвэр гарсныг шилэн дансанд мэдээлээгүй, шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 75 хувь байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын дүнгээр шилэн дансны зөрчлийг арилгуулах албан шаардлага өгөгдлөө.

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 70.4 сая төгрөгийн зөвлөмж өгөгдсөнийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	2	70,400.0		0	0%
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>70,400.0</b>		<b>0</b>	<b>0%</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй.

Аудитаар нийт 107.6 сая төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс, 107.6 сая төгрөгийн албан шаардлага өгч, зөвлөмж өгөгдөөгүй.

Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн эсэх байхгүй.

#### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт байхгүй.

#### 5.2 Албан шаардлага

Аудитаар дараах 68.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөгдлөө. Үүнд:

1.Сургууль оны эхэнд хүнсний материалын дансанд 53,971.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан бөгөөд тайлант онд 218,646.7 сая төгрөгийн хүнсний материалыг худалдан авч, 179,646.1 төгрөгийн хүнсний материалыг зарцуулж, 92,972.5 мянган төгрөгийн

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

үлдэгдэлтэй гарч, өмнөх оны эхний үлдэгдлээс 39,000.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн нь хүнсний материалыг их хэмжээгээр нөөцөлсөн гэж үзэх үндэслэлтэй ба чанар байдал алдаж муудах, төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах эрсдэлтэй, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

2. Тогооч нарт 505.0 мянган төгрөгийн цалин, 1,312.4 мянган төгрөгийн зэргийн нэмэгдлийг олгоогүй, төрийн үйлчилгээний ажилтнуудын ур чадварыг үнэлж дүгнээгүй байна.

3. Шилэн дансанд төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 66,847.4 мянган төгрөгийн 7 шийдвэр гарсныг шилэн дансанд мэдээлээгүй, шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 75 хувьтай байна.

### 5.3 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Дүн</b>												

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалин тогтоолтыг шалгаж үзэхэд	1	1,817.4			1	1,817.4						
Хүнсний материалын үлдэгдлийг 39,000.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж,	1	39,000.6			1	39,000.6						

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй												
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>40,818.0</b>			<b>2</b>	<b>40,818.0</b>						

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах тухай 8 шийдвэрийг гарсны, мэдээлээгүй	1	66,847.4			1	66,847.4		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>66,847.4</b>			<b>1</b>	<b>66,847.4</b>		
Засгийн газрын тогтоол, сайдын тушаалтай холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>66,847.4</b>			<b>1</b>	<b>66,847.4</b>		